



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/492

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /д/, 29.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38.1, 42.1.6, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 дугаар сарын 5-ны өдрийн “ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үнэмлэх олгох журам батлах тухай” А/109 дүгээр тушаалыг хэрэгжүүлж үнэмлэх хэвлүүлэх болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Сэргээн засалт үндэсний төвөөс 2017 оны 9 дүгээр сарын 13-нд Улаанбаатар хотноо зохион байгуулах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгаалал” үндэсний форумд оролцох хүүхэд, асран хамгаалагчдын зардлыг тус тус хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 6140000 /Зургаан сая нэг зуун дөчин мянган/ төгрөгийг хуваарилагдаагүй бусад зардлын “Нийгмийн халамжийн зөвлөлийн арга хэмжээний зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
08 дугаар сарын 30 -ний өдрийн  
492 дугаар захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын утга	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт дүн
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх	3000	1980	5940000
2	Форумд оролцох замын зардал	4	50000 /2талдаа/	200000
Нийт дүн				6140000

-00-